



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 19,900,000.00 (арван есөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 11,718,888.66 (арван нэгэн сая долоон зуун арван найман мянга найман зуун наян найман төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу салбар компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
 483 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	2019 оны 292 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ	Шинэчлэн тогтоосон үнэ
			(Төгрөг)				
1	Ниссан Экстрайл, 22-26 ОРХ, NT30205443	2006/2014	19,900,000.00	11,718,888.66	8,181,111.34	5,000,000.00	3,000,000.00
Нийт дүн			19,900,000.00	11,718,888.66	8,181,111.34	5,000,000.00	3,000,000.00
			(арван есөн сая есөн зуун мянган)	(арван нэгэн сая долоон зуун арван найман мянга найман зуун наян найман төгрөг жаран зургаан мөнгө)	(найман сая нэг зуун наян нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг гучин дөрвөн мөнгө)	(таван сая)	(гурван сая)